



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 7,475,425.36 (долоон сая дөрвөн зуун далан таван мянга дөрвөн зуун хорин таван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Ховд аймаг дахь бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал Л.Гэрэлсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Газар эзэмших эрхийг эмнэлгийн эзэмшилд хэвээр үлдээж зориулалтын дагуу ашиглах, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132002455

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, зориулалт	Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Мах хадгалах зоорийн барилга	1998	1	2.284.347,94
2	Механик цехийн барилга	1975	1	2.874.831,75
3	Ногоо хадгалах барилга	1998	1	365.495,67
4	ЦТП Узелийн барилга	1975	1	1.950.750
ДҮН				7.475.425,36
				(долоон сая дөрвөн зуун далан таван мянга дөрвөн зуун хорин таван төгрөг гучин зургаан мөнгө)